



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2018 оны 09 сарын 20 өдөр

Дугаар A/106

Улаанбаатар хот

Арилжаанд оролцох эрх олгох тухай

Монгол улсын Компанийн тухай хуулийн 83 дугаар зүйлийн 83.1, “Монголын хөрөнгийн бирж” төрийн өмчит хувьцаат компанийн Дүрмийн 8 дугаар зүйлийн 8.1, 8.10.11 дэхь заалт, “Үнэт цаасны арилжаанд оролцох эрх олгох журам”-ын 2 дугаар зүйлийн 2.3.1 дэх заалт, “Новел инвестмент ҮЦК” ХХК-ийн хүсэлтийг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Монголын хөрөнгийн биржийн гишүүн “Новел инвестмент ҮЦК” ХХК-ийн ажилтан Ё.Эрдэнэхүүд үнэт цаасны арилжаанд оролцох эрх нэмж олгосугай.
2. Арилжаанд оролцох эрх авсан гишүүн ҮЦК-ийн ажилтанд Монгол улсын үнэт цаасны зах зээлд мөрдөгдөж буй хууль, тогтоомж, журам, зааврыг үйл ажиллагаандаа чанд мөрдөж, өндөр хариуцлага, ёс зүйтэй ажиллахыг үүрэг болгосугай.
3. Үнэт цаасны арилжааны программд нэвтрэх нэр, нууц үг олгох ажлыг Үйл ажиллагааны газрын Арилжааны алба /Д.Алдармаа/-нд, тушаалын биелэлтэд Хяналт тавьж ажиллахыг Хяналт, зохицуулалтын газрын Хяналт шинжилгээний алба /Д.Баттулга/-нд тус тус даалгасугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Х.АЛТАЙ

000654